



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.08.31 № 1331

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Гантөгсийн Болормөнхийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, "Алсын хараа 2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

## Дүгнэлт

Иргэн Гантөгсийн Болормөнхийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Гантөгсийн Болормөнхийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (2. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ГАНТӨГС ОВОГТОЙ БОЛОРМӨНХИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020.07.24

Улаанбаатар хот

ШУДАРГА ЁС, НЭЭЛТТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Бие даан нэр дэвшигч нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд иргэний дуу хоолой, иргэний хяналтын үүргийг гүйцэтгэх ёстой гэж бодож байна. Өнгөрсөн хугацаанд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох иргэдийн хуралд сонгогдсон төлөөлөгчид иргэдээ төлөөлөхөөс илүүтэй намыг, бизнесийг, бүлэглэлийг төлөөлж ирсэн байна. Иргэдээс сонгогдсон атлаа иргэндээ дарга болж, иргэдээсээ холдох болсон нь хамгийн том алдаа гэж үзэж байна. Өнөөдөр ч байдал хэвээрээ буюу иргэдийн хурлын төлөөлөгчийг намаас нэр дэвшүүлж байгаа тул тэд сонгогдсон өвөөд эргээд намаа төлөөлөх нь гарцаагүй. Иймийн учир миний бие бие даан нэр дэвшиж иргэдээ төлөөлөн ажиллаж, сонгогчдын эрх ашгийн өмнөөс дуугарч, иргэдийн хөндөгдсөн эрх ашгийг хамгаалах чиглэлд ажиллана.

**Үүний тулд дараахь 5 зарчим дагуу ажиллана. Үүнд:**

Нэг. Ямагт иргэдийн талд байна.

Хоёр. Шударга ёсыг тогтоохын төлөө ажиллана.

Гурав. Хүний эрх эрх чөлөөг хамгаалагч байна.

Дөрөв. Албан түшаал, авлига, хээл хахуулиас ангид ажиллана.

Тав. Төр иргэндээ нээлттэй байх зарчмыг баримтлана.

Дээрх зарчмын дагуу НИТХ-ын хуралд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

1. Иргэдийн төлөөлөгчийн хувьд иргэдэд мэдээлэл өгөх өдрийг бий болгон мэдээлж ажиллана.
2. Иргэний танхимын үйл ажиллагааг бодитоор сэргээж иргэдийн санаа бодлыг сонсох үйл ажиллагааг 7 хоногт тогтсон нэг өдөр гарган зохион байгуулна.
3. НИТХ-ын хэлэлцэх асуудлын талаар иргэддээ мэдээлэл хийж, байр сууриа илэрхийлнэ.
4. НИТХ-аар хэлэлцсэн асуудлаар иргэддээ зориулж мэдээлэл хийж, байр сууриа илэрхийлж байна.
5. НИТХ болон Нийслэлийн Засаг дарга, харьяа байгууллагуудаас гаргасан Олон нийтийн эрх ашигт харшилсан аливаа шийдвэртэй эвлэрэхгүй байж, олон нийтийн эрх ашгийн төлөө тууштай тэмцэнэ.
6. Эрх ашиг нь хөндөгдсөн иргэдийн дуу хоолой болж ажиллана.
7. Нийслэлийн төр, захиргааны байгууллагад буй авлига, хээл хахуультай тэмцэж ажиллана.
8. Төрийн байгууллагын үйлчилгээний хүнд суртлыг халах чиглэлд санаачилгатай ажиллаж, асуудлыг шийдвэрлүүлэх тал дээр дээд удирдлагын хэмжээнд хүртэл ажиллана.
9. Улс төрийн томилгооны хохирогч болж хууль бусаар ажлаасаа чөлөөлөгдсөн, халагдсан төрийн албан хаагчдийн эрх ашгийг хамгаалан ажиллана.
10. Төрийн үйл ажиллагааг иргэд болон хэвлэл мэдээллийн байгууллагад нээлттэй болгох талаар шийдэл гарган үе шаттай ажиллана.
11. Нийслэлийн төсөв боловсруулахад иргэдийн санаа бодлыг тусгуулах, иргэдийн өмнө тулгамдсан нийтлэг бэхшээлийг шийдвэрлүүлэх талаар санаачилгатай ажиллана.



12. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлын үр дүн, гүйцэтгэл, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллан үр дүнг иргэдэд мэдээлж байх болно.
13. Хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлд иргэд, мэргэжлийн байгууллагуудын оролцоотой шийдэл гарган, НИТХ болон Нийслэлийн Засаг даргад уламжилж шийдвэрлэх талд хамтран ажиллана.
14. Нийслэлийн орчны тоосжилт, хөрсний бохирдлыг бууруулах, арилгах чиглэлд иргэд, мэргэжлийн байгууллагуудын оролцоотой шийдэл гарган, НИТХ болон Нийслэлийн Засаг даргад уламжилж шийдвэрлэх талд хамтран ажиллана.
15. Иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгын хүрээнд хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, гэр хорооллыг мөлжүүлэхтэй холбоотой ажлыг дэмжин ажиллана.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан

Бие даан нэр дэвшигч



Г.Болормонх

